



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/63

Жаргалтхаан сум

Монгол улсын иргэнд
газар өмчлүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 21 дүгээр зүйлийн 21.1 дахь заалт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Хоёрдугаар хуралдааны 07 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэр бүлийн хэрэгцээнд зориулан эзэмшиж буй хашааны газраа өмчлөх хүсэлт гаргасан иргэн Болдын Цогтбаатар (ЖБ65050971)-д тус сумын 5 дугаар баг Төвийн, Байц 1-123 хаягт байрлах, 4375544 төлөвлөлтийн нэгж талбарын дугаартай 750 квадрат метр газрыг өмчлүүлсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжид заасны хүрээнд газар өмчлөх эрхээ хэрэгжүүлж, өмчилж авсан газраа хуулийн дагуу кадастрын болон үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлэх, бусдад эзэмшүүлж ашиглуулах тохиолдолд эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэж зөвшөөрөл авахыг газар өмчлөгчид даалгасугай.

3. Иргэний өмчилсөн газарт кадастрын зураглал хийх, хилийн заагийг тэмдэгжүүлэх, улсын бүртгэлд бүртгэх, хяналт тавих үйл ажиллагааг хийж хэрэгжүүлэхийг сумын газрын даамал (Н.Ууганбаяр)-д даалгасугай.

ДАРГА



С.ГАНБАТ